


НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

Санамж: Нэгдүгээр хэсэг нийт 50 даалгавартай бөгөөд 1-25 дугаар даалгавар тус бүр 1 оноо, 26-41 дүгээр даалгавар тус бүр 2 оноо, 42-50 дугаар даалгавар тус бүр 3 оноотой. Сонгох даалгавраас зөвхөн нэг хариултыг сонгоорой.

- Улаан буудайг хамгийн их хэмжээтэй тариалдаг улс аль нь вэ?
 - Хятад
 - Япон
 - Испани
 - Португал
 - Бразил
- Таримал ургамал үүссэн төвүүдийг харуулсан зурагт Дундад Азийг хэдийн тоогоор тэмдэглэсэн бэ?



- 1
- 2
- 3
- 4
- 5

- Цэгийн оронд тохирох үгийг сонгоно уу. Тэнгис ба нуурлуу түрж орсон хуурай газрын хэсгийг гэнэ.
 - булан
 - садраа эрэг
 - хойг
 - арал
 - хоолой
- Монгол улсын эдийн засгийн Хангайн бүсэд хамрагдах аймгууд аль нь вэ?
 - Архангай, Өвөрхангай, Булган, Сэлэнгэ, Хөвсгөл, Баянхонгор
 - Архангай, Өвөрхангай, Булган, Хөвсгөл, Эрдэнэт, Баянхонгор
 - Архангай, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл, Баянхонгор, Булган
 - Завхан, Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Баянхонгор, Булган
 - Завхан, Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Булган, Хэнтий
- Аль улс нь хэмжээгүй эрхт хаант засаглалтай вэ?
 - Их Британи
 - Япон
 - Нидерланд
 - Норвеги
 - Лихтенштейн
- Музейн аялал жуулчлалаар хамгийн их жуулчин очдог газар аль нь вэ?
 - Парис
 - Москва
 - Чикаго
 - Мелбурн
 - Улаанбаатар
- Тус бүсийн бүх улс орнууд өндөр хөгжилтэй. Энэ аль бүс нутаг вэ?
 - Өмнөд Америк
 - Зүүн Европ
 - Баруун Европ
 - Өмнөд Ази
 - Зүүн өмнөд Ази

8. Цэгийн оронд байх зөв утгыг сонгоно уу. Соронзон орны векторын чиглэл ба хэмжээ нь хэвийн байдлаас өөр байх үзэгдлийг гэнэ.
- A. соронзон шуурга
B. соронзон туйл
C. соронзон гаж
D. соронзон гүр
E. соронзон азимут
9. Хүн ам ихээр төвлөрсөн хот суурин газруудад шуугиан, тоосжилт, зүрх судасны болон амьсгалын замын өвчин ихсэх хандлагатай байна. Эдгээрийг юу гэж нэрлэдэг вэ?
- A. Бохирдолт
B. Дуу чимээний бохирдол
C. Хотжилтын өвчин
D. Бөөгнөрөл
E. Шилжилт
10. Онон гол хаанаас эх авдаг вэ?
- A. Хянганы уулсаас
B. Хангайн нуруунаас
C. Хэнтийн нурууны баруун өмнө хажуугаас
D. Монгол Алтайн Таван богд уулнаас
E. Хэнтийн нурууны араас
11. Цэгийн оронд тохирох үгийг олно уу. тоо толгойгоор улс тэргүүлнэ. Лалын шашны зан үйлээс улбаалан зарим улс орнууд аж ахуйг хөгжүүлдэггүй.
- A. Адууны, Хятад, гахайн
B. Адууны, Энэтхэг, адууны
C. Гахайн, Энэтхэг, хонины
D. Хонины, Австрали, ямааны
E. Гахайн, Хятад, гахайн
12. Хойд мөсөн далайн ай савд хамаарах гол аль нь вэ?
- A. Дэлгэр, Хануй
B. Онон, Онги
C. Тэс, Завхан
D. Эг, Таац
E. Улз, Байдраг
13. Монгол улсын баруун захын цэгийн солбицол аль нь вэ?
- A. х.ө $46^{\circ} 52'$ з.у $103^{\circ} 50'$
B. х.ө $48^{\circ} 53'$ з.у $87^{\circ} 44'$
C. х.ө $46^{\circ} 43'$ з.у $119^{\circ} 56'$
D. х.ө $52^{\circ} 09'$ з.у $98^{\circ} 57'$
E. х.ө $41^{\circ} 35'$ з.у $105^{\circ} 00'$
14. Хамгийн олон угсаатан ястан амьдардаг аймгийг сонгоно уу.
- A. Увс
B. Ховд
C. Баян-Өлгий
D. Говь-Алтай
E. Архангай
15. Дараах нууруудаас аль нь тектоникий гаралтай вэ?
- A. Толбо, Даян
B. Буйр, Хөвсгөл
C. Хөвсгөл, Тэрхийн цагаан
D. Тэрхийн цагаан, Хагийн хар
E. Толбо, Хяргас
16. 13-р зуунд Европоос Монголд ирсэн жуулчин Марко Поло ямар нэртэй ном бичсэн бэ?
- A. Монгол ба Кам
B. Орчлонгийн элдэв сонин
C. Баруун хойд Монголын тодорхойлолт
D. Монгол орны физик газарзүйн тодорхойлолт
E. Баруун монгол ба Урианхайн хязгаар


17. Манай улсын аль аймаг ОХУ-ын Алтайн БНУ-тай хиллэдэг вэ?

- A. Сүхбаатар
B. Ховд
C. Баян-Өлгий
D. Сэлэнгэ
E. Архангай

18. Аль нь хөгжиж буй улс вэ?

- A. Герман
B. Швед
C. Канад
D. Сингапур
E. Мексик

19. Дараах бүдүүвчид байгаа асуултын тэмдгийн оронд тохирох үгийг олно уу?



- A. мөчлөгийн ажилгүйдэл
B. ажилгүйдлийн өндөр түвшин
C. энгийн ажилгүйдэл
D. ажлын байрны хангамж
E. ажилгүйчүүд

20. Монголчууд эрт үеэс булаг шандны эхийг цэвэр байлгах, голын усанд бохир оруулахгүй байхыг эрхэмлэж иржээ. Гэвч сүүлийн жилүүдэд хүний үйл ажиллагаанаас болж голын ус бохирдож байна. Доор дурьдсан нөлөөллөөс аль нь хүний үйл ажиллагаанд хамаарахгүй вэ?

- A. Ойг огтлох
B. Үйлдвэрийн хаягдал хаях
C. Ашигт малтмал олборлохдоо усыг их хэмжээгээр ашиглах
D. Автомашинга гол дотор угаах
E. Шар усны үерийн ус голд цутгах

21. Дараах үйл явцуудын аль нь химийн өгөршилд хамрагдах вэ?

- A. Уулын чулуулаг салхины нөлөөгөөр бутрах
B. Температурын зөрүүнээс болж чулуулаг үйрч бутрах
C. Боржин өгөршиж шаазангийн шавар болох
D. Хүндийн хүчний нөлөөгөөр гүдгэр гадаргуугаас хөндийрүү шилжих, бутрах
E. Ургамлын үндэсний хөгжлөөс болж чулуулаг бутрах

22. Цэгийн оронд тохирох үгийг сонгоно уу. Халуун бүслүүр нь хоёр талаасаа жилийн⁰C-ийн изотермээр зааглагдана.

- A. +20
B. 0
C. +10
D. -5
E. -10

23. Цэгийн оронд тохирох үгийг сонгоно уу. Дулааны цахилгаан станц, үйлдвэрийн яндангаас гарсан сульфатын давхар исэл, азотын ислүүд, суспензууд зэрэг хатуу хольцууд борооны дусалтай нэгдэн үүсгэнэ.

- A. хүчиллэг бороо
B. шүлтлэг бороо
C. цасан шуурга
D. мөндөр
E. аянга

24. Дараах хариултуудаас 1:100 000 масштабтай зургийн хуудасны нэрлэлийг сонгоно уу.

- A. K-48-A
B. K-48
C. K-48-123
D. K-48-123-A
E. K-48-123-A-a


25. Цэгийн оронд тохирох үгийг сонгоно уу. Аливаа юмс, үзэгдлийн тархалт, байршлын хил хязгаарыг өнгө, зураас, үсэг бичиг болон шугамыг ашиглан үзүүлэх аргыг гэнэ.

- A. цэгийн арга
- B. талбайн арга
- C. ижил шугамын арга
- D. тэмдэгтийн арга
- E. хөдөлгөөнт шугамын арга

26. Хүн амын өсөлтийг хэрхэн тооцоолдог вэ?


- A. Нийт хүн амын тооноос тухайн жилд нас барсан хүнийг тоог хасна
- B. Тодорхой хугацааны дотор төрсөн хүүхдийн тоог 1000-д хуваана
- C. Тодорхой хугацааны дотор төрсөн хүүхдийн тооноос, нас барсан хүний тоог хасаж, 1000-д хуваана
- D. Тодорхой хугацааны дотор төрсөн хүүхдийн тоог нийт нас барсан хүний тоонд хуваана
- E. Тодорхой хугацааны дотор төрсөн хүүхдийн тоог нийт нас барсан хүний тоонд хувааж, 1000- аар үржүүлнэ

27. Үндэстний нийтлэг хэв шинжийг тодорхойлох дараах бүvүүвчийн хоосон нүдэнд тохирох үгийг олно уу.



- A. улс төрийн
- B. нэгдмэл нэг нутаг дэвсгэр
- C. том хотууд
- D. нийслэл хот
- E. аймаг

28. Хөрсний зүсэлтийн зурагт А үсгээр юуг тэмдэглэсэн бэ?




- A. Дээд хөрс
- B. Доод хөрс
- C. Гадарга
- D. Эх чулуулаг
- E. Угаагдлын үе

29. Өвөрхангай аймаг дахь аялал жуулчлалын үзмэрүүд аль нь вэ?

- A. Хар хорин, Өгчлөгчийн хэрэм, Рашаан хад, Отгонтэнгэр уул, Хүйсийн найман нуур
- B. Хөвсгөл нуур, Даян дээрхийн агуй, Улаан цутгалан, Талын агуй, Амарбаясгалант хийд
- C. Түвхэн хийд, Эрдэнэ зуу, Хүйсийн найман нуур, Улаанцутгалан, Хужирт
- D. Хамрын хийд, Даян дээрхийн агуй, Рашаан хад, Амарбаясгалант хийд, Ээж мод
- E. Орхоны хөндий, Өглөгчийн хэрэм, Хар зүрхний хөх нуур, Балдан бэрээвэн хийд,

30. Зурагт үзүүлсэн рельефийн хэлбэр геоморфологийн ямар үйл явцын үр дүнд үүссэн бэ?



- A. Салхины үйл ажиллагаагаар
- B. Урсгал усны үйл ажиллагаагаар
- C. Галт уулын дэлбэрэлтээр
- D. Мөсөн голын үйл ажиллагаагаар
- E. Газар хөдлөлтөөр

31. Хүн амын нас хүйсийн суваргын 20-24 насны хүн амын тоо бага байхад нөлөөлсөн гол хүчин зүйл аль нь вэ?




- A. Аж үйлдвэрийн хувьсал
- B. Дэлхийн хоёрдугаар дайн
- C. 60000 орчим казах иргэд Казахстан улсруу шилжсэн
- D. Зуд болсон
- E. Ган болсон

32. Ямааны аж ахуй эрхлэхэд тохиромжтой мал аж ахуйн муж аль нь вэ?

- A. Алтай- Хан хөхийн уулт хээрийн муж
- B. Хангай- Хөвсгөл- Хэнтийн ойт хээрийн муж
- C. Төв ба Дорнодын тал хээрийн муж
- D. Булнайн нуруу
- E. Хянганы уулс

33. Б.П.Алисовын ангилалаар хийгдсэн Евразийн уур амьсгалын бүсийн зурагт 3- ийн тоогоор ямар бүсийг тэмдэглэсэн вэ?



- A. Тропикийн
- B. Экватор орчмын
- C. Сэрүүн
- D. Туйл орчмын
- E. Туйлын

34. Арлуудыг орших далайтай нь зөв тохируулна уу.

- | | |
|------------------------|----------------------|
| 1) Маскарены арлууд | a) Номхон далай |
| 2) Маршалловын арлууд | b) Атлантын далай |
| 3) Багамын арлууд | c) Умард мөсөн далай |
| 4) Франц Иосифийн арал | d) Энэтхэгийн далай |
- A. 1a, 2c, 3d, 4b
 B. 1b, 2c, 3d, 4a
 C. 1c, 2a, 3b, 4d
 D. 1d, 2a, 3b, 4c
 A. 1a, 2d, 3c, 4c

35. 2 цагийн хугацаанд дэлхий тэнхлэгээ хэдэн градусаар эргэх вэ?

- A. 60° B. 15° C. 30° D. 75° E. 45°

36. Дэлхийн газрын тосны нөөцийн 25,9% болох 259 тэрбум тн газрын тос нь улсын нутаг дэвсгэрт бий.

- A. Саудын Араб
- B. АНУ
- C. Канад
- D. Казахстан
- E. ОХУ

37. 2006 онд 14 аймгийн 76 сум, нийслэлийн 7 дүүргийн нутаг дэвсгэрт 205 удаа удаа түймэр гарсны улмаас ойн 321476 га талбай, хээрийн 641256 га талбай шатсан. Нийт хэдэн км^2 газар түймэрт өртсөн бэ?

- A. 962732 км^2
- B. 962732 га
- C. 952745 км^2
- D. $9527,32 \text{ км}^2$
- E. $9627,32 \text{ км}^2$

38. Өмнөд Азийн орнуудын экспортын гол бүтээгдэхүүн юу вэ?

- A. Газрын тос, арьс ширэн эдлэл
- B. Машин, цахилгаан- радио техник, химийн үйлдвэрлэл
- C. Олс, каучук, автомашин, мэдээлэл технологийн салбарын бүтээгдэхүүн
- D. Төмрийн хүдэр, үнэт мод
- E. Бэлэн хувцас, машин, газрын тос

39. Байгалийн унаган төрхийг хамгаалах төрөл бүрийн арга зам байдаг. Манай улсын тусгай хамгаалалттай 61 газар байдаг. Эдгээрээс доор өгөгдсөн газруудыг орших аймагтай нь харгалзуулснаас зөвийг нь сонгоно уу.

- | | |
|------------------|--------------|
| 1) Алтан элс | a) Увс |
| 2) Ганга нуур | b) Дорнод |
| 3) Монгол дагуур | c) Дорноговь |
| 4) Их нарт | d) Сүхбаатар |
- A. 1a, 2d, 3b, 4c
 B. 1b, 2d, 3c, 4a
 C. 1b, 2a, 3d, 4c
 D. 1a, 2c, 3d, 4b
 E. 1b, 2c, 3d, 4a

40. Хүснэгтэнд өгөгдсөн мэдээллийн зөв тохируулна уу.

Тэнгисийн нэр	дугаар	Далайн нэр	Тэмдэглэгээ
Арабын	1	Номхон	a
Умард	2	Умард мөсөн	b
Агнуурын	3	Атлантын	c
Лаптевын	4	Энэтхэгийн	d

- A. 1c, 2a, 3d, 4b
 B. 1d, 2b, 3a, 4c
 C. 1b, 2a, 3c, 4d
 D. 1d, 2c, 3a, 4b
 E. 1b, 2d, 3c, 4a


41. Хүн ам нь 10 саяас дээш, газар нутгийн хэмжээ нь 1 сая км²- аас бага улс орнууд аль нь вэ?

- A. Австрали, Канад, Чили, Энэтхэг, ОХУ
 B. Бразил, Япон, АНУ, ОХУ, Малайз
 C. Саудын Араб, Алжир, АНУ, Өмнөд Солонгос, ОХУ
 D. Аргентин, АНУ, ОХУ, Монгол, Япон
 E. Испани, Уганда, Герман, Сири, Вьетнам

42. Дэлхийн төмрийн нөөцийн 1/8, зэсийн 1/4 байдаг. Гадил, нимбэг, элсэн чихэр, кофены экспортоор дэлхийд тэргүүлдэг ба эргийн зарим улсад Эль-нино урсгалын нөлөө 4-5 жилд давтагддаг бол энэ аль бүс нутаг вэ?

- A. Европ
 B. Өмнөд Ази
 C. Өмнөд Америк
 D. Төв Америк
 E. Австрали- Шинэ Зеланд

43. Габон болон Камерун улсуудад газар тариалан эрхлэхэд тааламжтай бөгөөд, уур амьсгалд нь нөлөөлж буй далайн урсгалыг зурагт хэдийн тоогоор тэмдэглэсэн бэ?




- A. 11
 B. 4
 C. 3
 D. 8
 E. 2

44. Агаар бохирдуулагч элемент ба түүний эх үүсвэрийг зөв харгалзуулна уу.

- | | |
|---------------------|---|
| 1) Азотын ислүүд | a) Амьсгал, түлшний шаталт, үйлдвэр |
| 2) Суспензүүд | b) Гэрэлтүүлэг, хөрсний микробууд, биомассын шаталт |
| 3) Нүүрсхүчлийн хий | c) Цагаан будааны тариалан, хөрсний гулсалт, амьтан |
| 4) Метан | d) Далайн давс, тоос шороо |


- A. 1c, 2a, 3d, 4b
 B. 1b, 2d, 3a, 4c
 C. 1d, 2a, 3c, 4b
 D. 1a, 2d, 3c, 4b
 E. 1b, 2c, 3a, 4d

45. Дараах зурагт тохирох хамгийн оновчтой үг аль нь вэ?




- A. Хот
 B. Хөдөө
 C. Дэд бүтэц
 D. Агломераци
 E. Гадаад шилжилт

46. Дараах зурагт анхдагч үйлдвэрлэлийн салбарт ажиллагчдын хувь хэмжээгээр хамгийн их улс хэдийн тоогоор тэмдэглэгдсэн бэ?




- A. 6
 B. 5
 C. 4
 D. 3
 E. 2

47. Дөрвийн тоогоор хотын ямар функцийг тэмдэглэсэн бэ?




- A. Орлого багатай иргэдийн орон сууц
- B. Дундаж орлоготой иргэдийн хороолол
- C. Баячуудын хороолол
- D. Хүнд аж үйлдвэр
- E. Бөөний худалдаа, хөнгөн үйлдвэр

48. Б цэгт арслан, дэлт чоно, матар, анааш зэрэг амьдын зураг авах аялал хийсэн жуулчин А цэгт очин сафари аялал хийсэн. Жуулчин байгалийн ямар бүсээс ямар бүсэд очсон бэ?




- A. Саванны бүсээс цөлийн бүс рүү
- B. Саванны бүсээс хатуу навчит ой , бутлаг ургамлын бүс рүү
- C. Экваторын чийглэг ойгоос саванны бүс рүү
- D. Экваторын чийглэг ойгоос цөлийн бүс рүү
- E. Цөлийн бүсээс саванны бүс рүү

49. 2007 он гарсаар Өвөрхангай аймагт 6, Ховд аймагт 3, Завхан аймагт 1, Төв аймагт 1 удаа, нийт 11 удаа аадар бороо, үер буусны улмаас 4 хүн нас барж, 4714 толгой мал хорогджээ. Монгол улсын газрын зурагт эдгээр аймгуудыг хэдийн тоогоор тэмдэглэсэн вэ?



- A. 8, 5, 6, 11
- B. 11, 8, 5, 12
- C. 12, 11, 6, 15
- D. 14, 8, 11, 6
- E. 1, 3, 6, 14

50. Б цэг дээр агаарын температур $+5,5^{\circ}\text{C}$ байсан бол А цэг дээр хэдэн хэм байхыг бодож олно уу?



- A. $1,3^{\circ}\text{C}$
- B. $-2,6^{\circ}\text{C}$
- C. $-1,3^{\circ}\text{C}$
- D. $1,5^{\circ}\text{C}$
- E. $-1,8^{\circ}\text{C}$

ХОЁРДУГААР ХЭСЭГ. ТООЦООЛОХ ДААЛГАВАР

Санамж: Хоёрдугаар хэсэг нь тус бүр 4 оноотой 4 даалгавраас бүрдэнэ. Даалгаврын хариуг хариултын хуудсанд дараах байдлаар тэмдэглэнэ үү. *Жишээлбэл:*

- *Эцсийн хариу 342 гэж гарсан бол a-3, b-4, c-2 гэж бөглөнө.*
- *Нарны өндөр олох бодлогын хариу $75^{\circ}28'$ гэж гарсан гэж үзвэл a-7, b-5, c-2, d-8 гэж бөглөнө.*

2.1. Улаанбаатар хот х.ө $47^{\circ}55'$, з.у 107° оршдог. Тэгвэл 3 дугаар сарын 21-нд үдийн нарны өндөр хэдэн градус, хэдэн минут байхыг бодож олно уу.

2.2. 1:500000 масштабтай зураг дээр 8 см зурагдсан зай 1:25000 масштабтай зураг дээр хэдэн см зурагдах вэ?

2.3. з.у 62° - т орших нутагт 19 цаг болж байхад Улаанбаатар хотод хэдэн цаг болж байх вэ?

2.4. Тухайн голын өргөн 48 м, голын хамгийн гүн хэсэг нь 5 м бол голын хөндлөн огтлолын талбай хэдэн м^2 байх вэ?